



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАРАГТ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 04 сарын 28 өдөр

Д.Э.Р. 09/06

Тарагт сум

Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 4.2, 4.4, 3.3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төсөл сонгон шалгаруулах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.  
Дарга: Б.Батцэцэг (Засаг даргын Тамгын газрын дарга)  
Нарийн бичгийн дарга: Ж.Энхбат (Хүнс, жижиг дунд хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүдэд: Б.Саруул (Санхүү албаны дарга)

Р.Адъяадулам (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

З.Солонго (Төрийн бус байгууллагын төлөөлөл)

2. Журмын хэрэгжилт болон холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 23 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ОДОНТУЯА